



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний Аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд /Ч.Улаан/ нарт зөвлөсүгэй.

4. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор /С.Энхбаатар/-т даалгасугай.

5. Аудитын тайланг баталсан өдрөөс хойш 30 хоногийн дотор архивын нэгж үүсгэн хүлээлгэн өгөхийг Нийцлийн аудитын багт, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор /С.Оюунбилэг/-т тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ



Агуулга

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт.....	1
Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар	Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	3-4
Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор	Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт.....	5-6
С.Энхбаатар	Үндсэн мэдээлэл.....	7
Аудитын менежер Х.Болдбаатар	БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ БОЛОН ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА	7-27
Ахлах аудитор Б.Алтансүх	1.1. ОНХНС-ийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлсэн байна.....	7-11
Аудитор Л.Нямтөмөр Б.Чимэдлхам	1.2. ОНХС-ийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу зарцуулаагүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүд давтан гарсаар байна.....	11-19
	1.3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.....	19-21
	1.4. ОНХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж буй журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх шаардлагатай байна.....	21-28
2018 оны 12 дугаар сар	БҮЛЭГ 2. СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.....	28-40
Уг тайланг ҮАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү. www.audit.mn	2.1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлээгүй байна.....	28-30
Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729, 260949 дугаарын утас, факсаар харилцана уу.	2.2. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй зарцуулаагүй, зарим аймгийн Төсөл сонгон шалгаруулах зөвлөл ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн байж болзошгүй зөрчил илэрсэн байна.....	30-32
	2.3. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.....	32-38
Хаяг:	2.4. Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж буй журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх замаар СХС-д үүсээд байгаа хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийг эргэн төлүүлэх арга хэмжээг яаралтай авах шаардлагатай байна.	38-40
Үндэсний аудитын газар	БҮЛЭГ.3 ӨМНӨХ ОНЫ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 84.7 ХУВЬТАЙ БАЙНА	41-42
Засгийн газрын IY байр	Холбогдох байгууллагын санал	
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот 15160	Саналд өгөх тайлбар	
Монгол Улс	Дүгнэлт	43
	Зөвлөмж	44
	Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	
	Хавсралт.....	45-53



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНХ	Иргэдийн Нийтийн хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МЭҮТ	Мал эмнэлгийн үндэсний төв
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НАГ	Нийцлийн аудитын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНО	Олон нийтийн оролцоо
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОУВС	Олон улсын валютын сан
СХД	Сонгино хайрхан дүүрэг
СХС	Сум хөгжүүлэх сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЯ	Сангийн яам
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХТШ	Хязгаарлагдмал тендер шалгаруулалт
ЭЗХТ	Эдийн засаг төлөвлөлтийн хэлтэс



ХҮСНЭГТ, ГРАФИКТ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

График 1	ОНХНС-д 2013-2017 онд хуваарилсан хөрөнгийн хэмжээ
График 2	ОНХС-ийн орон нутгаас төвлөрүүлсэн орлого
График 3	ОНХС-ийн эх үүсвэр, илэрсэн зөрчлийн харьцаа
График 4	СХС-аас 2016-2017 онд олгосон зээлийн судалгаа
График 5	ОНХС-ийн өмнөх аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
График 6	СХС-ийн өмнөх аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
Хүснэгт 1	ОНХНС болон улсын төсвийн эх үүсвэрийн төлөвлөлт
Хүснэгт 2	ОНХС-д 2017 онд төвлөрсөн эх үүсвэр
Хүснэгт 3	ОНХС-д олгосон шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт 4	ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааны тоон мэдээлэл
Хүснэгт 5	“Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэх тооцох аргачлал”-ын заалт, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтын харьцуулалт
Хүснэгт 6	“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын зарим заалт, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтын харьцуулалт
Хүснэгт 7	ОНХС-ийн хөрөнгөөр 2014-2017 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоон үзүүлэлт
Хүснэгт 8	Санал, асуулгын дүн
Хүснэгт 9	ҮАГ-ын 2013-2017 он хийсэн ОНХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн зөрчил
Хүснэгт 10	Аудитаар илэрсэн зөрчлийн ангилал
Хүснэгт 11	Сум хөгжүүлэх сангийн 2017 оны хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт /эх үүсвэрээр/
Хүснэгт 12	Сум хөгжүүлэх сангийн 2017 оны хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт /аймгуудын дүнгээр/
Хүснэгт 13	Сумын Засаг дарга нарын үйл ажиллагаатай холбоотой зөрчлүүд
Хүснэгт 14	Сумын ИТХ-ын үйл ажиллагаатай холбоотой зөрчлүүд
Хүснэгт 15	Зээлийн мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд оролцох субъектүүдийн чиг үүргийн харьцуулалт
Хүснэгт 16	Сум хөгжүүлэх сангийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын талаарх мэдээлэл



Аудит хийх үндэслэл

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2018 оны 03 дугаар “Аудитын сэдэв батлах тухай” тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/125 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сан болон Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх;
- Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх;
- Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад ОНХНС, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2017 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал, мөн Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, хяналт, тайлагналыг СЯ, ХХААХҮЯ болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, ЗДТГ, СТСХ, ЭЗТХ, Баг, хороодын Засаг дарга, ИНХ-ыг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, 400, 3000, 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, МУЕА-ын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан Нийцлийн аудитын түр журмыг баримтлан Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Аймаг, нийслэл, сумын Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн болон холбогдох хэлтсийн албан тушаалтантай ярилцах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Мөн аудитын хүрээнд ОНХС болон СХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн талаарх иргэдийн мэдээлэл, оролцоог үнэлэх зорилгоор 21 аймаг болон нийслэлийн нийт 14,923 иргэнээс санал асуулга авч нэгтгэн дүгнэв.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актууд болон аудитын стандартуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:



- Төсвийн тухай хууль;
- Иргэний хууль;
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль;
- Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль;
- Зээлийн мэдээллийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- МУЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай”;
- МУЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”;
- Зээлийн мэдээллийн сангийн журам;
- Монгол банкны ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2017 оны “Активыг ангилах бүртгэх тухай” журам;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”;
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”;
- Бусад холбогдох хууль тогтоомж.



Үндсэн мэдээлэл

Орон нутгийн хөгжлийн сангийн тухай


Орон нутгийн хөгжлийн сан /ОНХС/-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан /ОНХНС/-ийн эх үүсвэрийг НӨАТ, газрын тосны нөөц болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хайгуул, олборлолт хийх тусгай зөвшөөрлийн орлого зэрэг орлогын тодорхой хувиар¹ тооцож бүрдүүлдэг.

ОНХНС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг тооцохдоо МУЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын дагуу 2013-2017 онд нийт 655.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг Аймаг, нийслэл, сум, дүүрэгт хуваарилсан байна. ОНХНС-д 2013-2017 онд хуваарилсан хөрөнгийн хэмжээг харуулбал:

График.1 ОНХНС-д 2013-2017 онд хуваарилсан хөрөнгийн хэмжээ

(сая төгрөг)



Эх сурвалж: Сангийн яамны Орон нутгийн хөгжлийн сан мэдээллийн сайтаас.

Мөн орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримтлан хэрэгжүүлж байна.

Аймаг, нийслэлийн ОНХС-д ОНХНС болон улсын төсвөөс 2017 онд гүйцэтгэлээр 45,861.5 сая төгрөг, төслийн эх үүсвэрээр 7,152.0 сая төгрөг, нийт 53,013.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, өмнөх оны үлдэгдэл 24,203.0 сая төгрөг, орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас 7,954.0 сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлснээр 11,060.3 сая төгрөг, хандив тусламжаар 5,211.8 сая төгрөг, зарлагыг хэмнэх болон бусад эх үүсвэрээр 6,010.4 сая төгрөг, нийт 107,452.5 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр Аймаг, нийслэл, сум, дүүргүүдийн ИТХ-аар 2017 онд нийт 3,852 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 89.4 хувь буюу 3,442 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 4.3 хувь буюу 167 төсөл, арга

¹ 59.1.1.импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь;

59.1.2.Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь;

59.1.5 газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь;



хэмжээ дутуу хэрэгжсэн, 5.7 хувь буюу 220 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн тухай

Сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Сум хөгжүүлэх сан” /СХС/-г анх МУЗГ-ын 1996 оны 258 дугаар тогтоолоор анх үүсгэн байгуулж, “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам, гэрээний загвар”-ыг МУЗГ-ын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталж, 2016 онд МУЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна.

2011-2017 оны хугацаанд тус сангийн удирдлага зохион байгуулалт Монгол Улсын Засгийн газрын тухай, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй уялдан 2011 онд Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын, 2012-2014 онд Хөдөлмөрийн сайдын, 2014-2016 онд Аж үйлдвэрийн сайдын, 2016 оноос хойш дахин Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байна. Дээрх нөхцөл байдлаас хамаарч орон нутагт сангийн удирдлага зохион байгуулалтыг Хөдөлмөрийн хэлтэс, аймгийн Засаг дарга, ХХААГ, сумдад 2011-2013 оны 4 дүгээр сар хүртэл хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, 2013 оны 4 дүгээр сараас 2017 оны 4 дүгээр сар хүртэл хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, 2017 оны 4 дүгээр сараас Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн хариуцаж ажиллаж байсан нь сангийн удирдлага, зохион байгуулалт тогтворгүй, тухайн аймгийн сангийн үйл ажиллагааны үзүүлэлттэй шууд хамаарч байна.

Тус сангийн хөрөнгийг бүрдүүлэх зорилгоор Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас 2011 онд 24.0 тэрбум төгрөг, Хөдөлмөрийн яамнаас 2012-2014 онд нийт 60.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг сумын хүн амын тоо, эдийн засгийн үзүүлэлттэй уялдуулан хуваарилсан бөгөөд нийт 84.0 тэрбум төгрөгийн шилжүүлэг хийсэн байна.

Тус санд 2014 оноос хойш улсын төсвөөс нэмж орлогын шилжүүлэг буюу хуваарилалт хийгдээгүй, зөвхөн зээлийн эргэн төлөлтөөс санг дахин санхүүжүүлэх зарчмыг баримтлан 68.3 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.²

Улсын хэмжээнд Сум хөгжүүлэх сангаас 2011-2017 оны байдлаар 5,928 иргэн, 25,273 аж ахуйн нэгжийн нийт 31,201 төсөлд 152.3 тэрбум төгрөгийн зээлийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгосон байна.

² ХХААХҮЯ-ны 2018.08.28-ны өдрийн 01/3179 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээлэл.



БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ БОЛОН ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.

1.1. ОНХНС-ИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ БҮРДҮҮЛСЭН БАЙНА.

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас болон улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 74,505.9 сая төгрөгөөр баталсныг ОУВС³-тай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, холбогдох өөрчлөлтийг төсөвт тусгах шаардлагын үүднээс Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар 53,013.5 сая төгрөг болгон тодотгосон байна.

Хүснэгт.1 ОНХНС болон улсын төсвийн эх үүсвэрийн төлөвлөлт

(сая төгрөг)

Эх үүсвэр		Батлагдсан	Тодотгол	Зөрүү
ОНХНС-аас олгох	Дотоодын НӨАТ-ын орлогын 5 хувь	20,739.5	20,739.5	-
	Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь	8,605.4	8,605.4	-
	АМНАТ-ийн орлогын 5 хувь	16,516.6	16,516.5	-
	"Тогтвортой амьжиргаа-3" төсөл		7,152.0	7,152.0
Улсын төсвөөс олгох	Мега төслийн АМНАТ-ийн 10 хувь	10,144.5	-	(10,144.5)
	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь	18,500.0		(18,500.0)
Нийт		74,505.9	53,013.5	(21,492.5)

Эх сурвалж: Сангийн яам

ОНХНС-аас ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн төлөвлөлтийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2⁴, 59.3⁵ дахь хэсэг, МУЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал" /Цаашид " МУЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан "ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал" гэж нэрлэнэ./-ын дагуу орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачилга гэсэн 4 төрлийн итгэлцүүрт үндэслэн тооцоолсон байна.

³ УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоол;

⁴ 59.2.Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна;

59.2.1.энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх;

59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

59.2.3.улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 60.2.6, 60.2.7-д заасан орлогын шилжүүлгийг 60 дугаар зүйлийн 60.6, 60.7-д заасан хувь хэмжээгээр хуваарилах. /Энэ хэсгийг 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/, /Энэ хэсгийг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

59.2.4.энэ хуулийн 59.1.3, 60.2.5-д заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй;

⁵ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

59.3.1.орон нутгийн хөгжлийн индекс;

59.3.2.хүн амын тоо;

59.3.3.хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ;

59.3.4.орон нутгийн татварын идэвх санаачилга.



“Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт дэмжих, орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, сайн гүйцэтгэлийг нэмэлт хөрөнгө хуваарилах замаар урамшуулах, төслийн удирдлага, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд сумдын ОНХС-ийн үйл ажиллагааг үнэлж, ОНХС-ийн хуваарилсан хөрөнгийн тодорхой хувийг урамшуулах замаар олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс 2017 онд 154 сумын ОНХС-д 7,152.0 сая төгрөгийн урамшуулал олгохоор төлөвлөж бүрдүүлжээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр баталсан хуулиар Төсвийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.6 дахь хэсэгт “Энэ хуулийн 60.7 дахь хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж зааснаар улсын төсвөөс Аймаг, нийслэлийн ОНХС-д олгох 2 төрлийн шилжүүлэг буюу Мега төслийн АМНАТ-ийн 10 хувь, Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50 хувийн шилжүүлгийг 2020 оноос тооцохоор болж, нийт 21,492.5 сая төгрөгийг бууруулж тодотгосон байна.

Зарим аймгууд ОНХС-аас сумдад олгох орлогыг шилжүүлэхдээ МУЗГ-ын 2010 оны 88 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн индекс тооцох аргачлал”-ын орон нутгийн хөгжлийн индекс⁶, орлогын шилжүүлэг тооцох аргачлал, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 3.2, 6.1, 12.2.5а, 12.2.5д, 12.2.7 дахь заалтуудыг тус тус баримтлаагүй байна. Үүнд:

- Говь-Алтай аймаг сумын хөгжлийн индексийг тооцож гаргаагүй, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг төлөвлөж хуваарилсан баримт материалгүй, мөн сумдын ОНХС-ийн батлагдсан төсвийг Бигэр, Тайшир, Тонхил, Халиун, Цээл сумдад төлөвлөж хуваарилаагүй;
- Хэнтий аймаг сумдын ОНХС-д олгох шилжүүлгийг “Төсвийн тухай” хуулийн 59.2 дахь хэсгийн дагуу “Хүн амын тоо”, “Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ” итгэлцүүрийг үндэслэн тооцож хуваарилахдаа “Орон нутгийн хөгжлийн индекс”, “Орон нутгийн татварын идэвх санаачилга итгэлцүүрийг ашиглаагүй;
- Орхон аймгаас “2017 оны төсвийн төсөл”-ийг Сангийн яаманд хүргүүлэхдээ ОНХС-ийн орлогын талаарх санал, сумдын ОНХС-д хуваарилах тооцоолол, төлөвлөлтийг хийгээгүй, сумдад хүргүүлсэн төсвийн төсөл боловсруулах удирдамжийг дээрх журамд нийцүүлээгүй байна.

Зарим аймаг, сумд ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө бусад эх үүсвэрээс орлого бүрдэх боломжтой байхад төлөвлөгөөнд тусгаагүй, зөвхөн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгээр төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2⁷ дахь хэсэгт ОНХС-ийн эх үүсвэр нь 6 төрлийн орлогоос бүрдэхээр заасан ч Баян-Өлгий, Завхан, Сэлэнгэ, Ховд, Увс аймаг, нийслэл ОНХС болон улсын төсвөөс хуваарилагдсан шилжүүлгийн орлогоос бусад эх үүсвэрийг төлөвлөөгүй нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1⁸ дэх заалт, МУЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “ОНХС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 2.2.2, 2.2.3, 2.2.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

⁶ ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 1.2.4;

⁷ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

⁸ төсвийн зарчмыг мөрдлөг болгох;



Сүхбаатар, Хөвсгөл зэрэг аймгууд орон нутгийн орлогоос журамд заасан нэр төрлөөс гурваас дээш эх үүсвэрийг төлөвлөж, бүрдүүлсэн байхад дор дурдсан аймаг, нийслэлийн удирдлагууд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.1 дэх заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгийн бусад эх үүсвэрийг хууль, журамд заасан нэр төрлөөр нь бүрдүүлэх талаар хангалтгүй ажилласан байна. Үүнд:

-Архангай, Булган, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Төв, Увс зэрэг аймгууд орон нутгийн орлогоос дээрх журамд заасан нэр төрлөөс нэг эх үүсвэрийг төлөвлөж, бүрдүүлсэн;
-Баянхонгор, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Өмнөговь, Хэнтий аймгууд орон нутгийн орлогоос журамд заасан нэр төрлөөс 2 эх үүсвэрээр төлөвлөж бүрдүүлсэн. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү/

Аймаг, нийслэлийн удирдлагууд ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлтийн тооцооллыг хуульд заасан аргачлалын дагуу хийгээгүйгээс сум, дүүргүүдэд төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр дутагдах, түүнчлэн төлөвлөгдөөгүй ажлууд хийгдэхэд хүргэсэн байна.

ОНХС-аас Аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг бүрэн олгосон байна.

Аймаг, нийслэлийн ОНХС-д 2017 онд нийт 107,452.5 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн бөгөөд 22.5 хувь буюу 24,203.0 сая төгрөг нь өмнөх оны үлдэгдэл, 49.3 хувь буюу 53,013.5 сая төгрөг нь ОНХНС болон улсын төсвийн шилжүүлэг, 7.4 хувь буюу 7,954.0 сая төгрөг нь үндсэн тэнцлийн ашиг, 10.3 хувь буюу 11,060.3 сая төгрөг нь татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр, 4.9 хувь буюу 5,211.8 сая төгрөг нь дотоод, гадаадын хандив тусламж, 5.6 хувь буюу 6,010.4 сая төгрөг нь зарлагыг хэмнэх болон бусад эх үүсвэрээс бүрдсэн байна. /Хавсралт 1/


Хүснэгт 2. Орон нутгийн хөгжлийн санд 2017 онд төвлөрсөн эх үүсвэр

(сая төгрөг)

Эх үүсвэр	Дүн	Хувийн жин
Өмнөх оны үлдэгдэл	24,203.0	22.5 хувь
ОНХНС болон улсын төсвөөс олгосон шилжүүлэг	53,013.5	49.3 хувь
Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас үлдэх хэсэг	7,954.0	7.4 хувь
Татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн	11,060.3	10.3 хувь
Хандив, тусламж	5,211.8	4.9 хувь
Зарлагыг хэмнэх болон бусад эх үүсвэр	6,010.4	5.6 хувь
НИЙТ	107,452.5	100 хувь

Эх сурвалж: Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын аудитын тайлангаас.

ОНХС-д 2017 онд орон нутгаас төвлөрүүлсэн эх үүсвэрийг 2016 онтой харьцуулахад үндсэн тэнцлийн ашгаас төвлөрүүлсэн орлого 0.9 тэрбум, хандив тусламж болон бусад орлого 7.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. ОНХС-д орон нутгаас төвлөрүүлсэн орлогыг графикаар үзүүлбэл:



Эх сурвалж: ҮАГ-ын 2014-2017 онд орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийсэн аудитын тайлан.



ОНХНС-аас Аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг бүрэн олгосон байна.

ОНХНС болон улсын төсвөөс олгох шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлсэн байна

Сангийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн “Төсвийн хуваарь батлах тухай” 331 дүгээр тушаалаар аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарийг баталсан байна.

Хүснэгт 3. ОНХС-д олгосон шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Хуваарь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I улирал	8,345.6	8,072.9	(272.7)
II улирал	21,401.1	21,673.8	272.7
III улирал	11,699.6	11,699.6	-
IV улирал	11,567.3	11,567.3	-
Нийт	53,013.5	53,013.5	-

(сая төгрөг)

Эх сурвалж: Сангийн яам.

Хүснэгтээс үзэхэд хуваарийг сар болгоны төлөвлөсөн орлогын эх үүсвэрээр баталсан тул аймаг, нийслэлийн ОНХС-д I улирлын гүйцэтгэл ашигт малтмалын нөөц ашигласны орлогын эх үүсвэр хоцорч төвлөрсөнтэй холбоотой зөрүү гарсан байна.

Зарим аймаг ОНХНС-аас олгосон шилжүүлгийг сумдад дутуу, аймагт илүү хуваарилж олгосон нь Төсвийн тухай хуулийн 59.2-т “Аймаг, нийслэл нь ОНХНС-аас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3⁹-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Баян-Өлгий аймаг ОНХС-аас олгох суурь зарлагыг хассан дүнгээс тооцож үзэхэд 37.0 хувийг сумуудын Орон нутгийн хөгжлийн санд, 63.0 хувийг аймгийн Орон нутгийн хөгжүүлэх санд хуваарилсан;
- Дархан-Уул аймаг ОНХНС-аас олгосон шилжүүлгийг 21.3 хувь буюу 194.9 сая төгрөгөөр сумдад дутуу хуваарилж олгосон.
- Дорноговь аймаг ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийн 50.3 хувь буюу 2,505.2 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 40.7 хувь буюу 2,442.4 сая төгрөгийг сумдын ОНХС-д хуваарилахаар төлөвлөсөн. Гэтэл МУ-ын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор тус аймагт 2,307.0 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг хуваарилахаар батлагдсан бөгөөд үүний 38.1 хувь буюу 880.6 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 77.3 хувь буюу 1,782.9 сая төгрөгийг сумдын ОНХС-д хуваарилахаар төлөвлөсөн байна.

ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг дутуу ирснээс сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг танасан бөгөөд сумдаас харилцан адилгүй хувь хэмжээгээр бууруулсан нь, ямар аргачлалаар тооцсон нь тодорхойгүй байна.

Цаашид ОНХС-ийн эх үүсвэр батлагдсан төлөвлөгөөнөөс буурсан тохиолдолд аймаг болон сум бүрт олгох шилжүүлгийн хэмжээг төсвийн өөрчлөлттэй

⁹ ОНХС-аас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно. 59.3.1 Орон нутгийн хөгжлийн индекс; 59.3.2 Хүн амын тоо; 59.3.3 Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ; 59.3.4 Орон нутгийн татварын идэвх санаачилга.



уялдуулан дахин тооцоолох, Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь заалтыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

1.2. ОНХС-ийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу зарцуулаагүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүд давтан гарсаар байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд нийт 94,531.7 сая төгрөгийн өртөгтэй 3,852 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсанаас 89.4 хувь буюу 75,715.4 сая төгрөгийн 3,442 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 4.3 хувь буюу 8,973.8 сая төгрөгийн 167 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн, 5.7 хувь буюу 5,811.1 сая төгрөгийн 220 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. /Хавсралт 3/

Аудитаар ОНХС-ийн хөрөнгийг үр дүнтэй төлөвлөж, зарцуулсан эсэхийг “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3 дахь заалтыг баримтлан улсын хэмжээд нэгтгэн дүгнэлээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг зарим аймаг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, зарцуулаагүй байна

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлд тухайн шатны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авч урьдчилсан жагсаалт бэлтгэн олон нийтээр хэлэлцүүлж, нийтийн эрх ашигт нийцсэн нэгдсэн жагсаалтыг ИТХ-д өргөн мэдүүлэхээр заасан.

Мөн дээрх журмын 6.3.4¹⁰, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 2.2¹¹, 4.1¹² дэх заалтуудад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр, УИХ, МУЗГ болон тухайн орон нутгаас хөгжлийн талаар баримталж байгаа бодлого стратеги, орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байхаар тусгасан байна.

Гэвч зарим аймаг, нийслэлийн удирдлага орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн, саналын урьдчилсан жагсаалт бэлтгээгүй нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 3.5, 5.7 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал:

- Сэлэнгэ аймаг 2017 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.1.17, 2.1.19 -т тусгагдсан 133.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бол бусад 452.6 сая төгрөгийн өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон Сэлэнгэ аймгийг 2013-2021 он хүртэл хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөртэй уялдаагүй;
- Ховд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс авах урьдчилсан жагсаалтыг гарган нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулаагүй, хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд нь үр дүнтэй болсон талаар ажлын тайлан мэдээ байхгүй, Өлзийт сум аймгийн чиг үүрэгт хамаарах “Сум хөх Бүрдийн тохижилтын ажлын дуусгалт”-ын ажилд 38.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан нь тэргүүлэх чиглэлтэй

¹⁰ орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх;

¹¹ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь УИХ, ЗГ болон тухайн орон нутгаас хөгжлийн талаар баримталж байгаа бодлого стратеги, түүнтэй холбоотой бусад бичиг баримттай уялдсан байна.

¹² ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр болон тухайн орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан байх



уялдаагүй, Эрдэнэдалай сум аймгийн чиг үүрэгт хамаарах “Мандалговь цэцэрлэгт хүрээлэнгийн дуусгалт”-ын ажилд 50.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан нь тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй;

- Хэнтий аймаг нийт 303.5 сая төгрөгийн 44 арга хэмжээ аймаг, сумын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдаагүй нь “ОНХС-ийн заавар”-ын 4.1 дэх зарчимтай нийцэхгүй байна. Үүнд: Аймаг, сумын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдаагүй дээрх арга хэмжээнүүдийн 34.0% нь “Үндэсний баяр наадам”, 11.4% нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, 11.4% нь золбин нохой, шумуул устгал зэрэг жил бүр зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. Мөн нийт 159.7 сая төгрөгийн 23 арга хэмжээ нь орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдээгүй ч эрэмбэлэгдсэн жагсаалтад орсон нь “ОНХС-ийн заавар”-ын 4.2 дэх зарчимтай нийцэхгүй байна. Үүнд: Баян-Овоо сум 4, Баянхутаг сум 9, Бор-Өндөр 2, Батширээт, Баянмөнх, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр сумууд, Өлзийт, Хурх тосгон тус бүр 1 арга хэмжээг иргэдийн саналаар дэмжигдээгүй байхад эрэмбэлсэн жагсаалтад оруулж баталж зарцуулсан байна.

Аудитаар орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн, саналын урьдчилсан жагсаалт бэлтгээгүй нийт 23 төсөл, арга хэмжээний 337.2 сая төгрөгийн зөрчилд 75.7 сая төгрөгийн албан шаардлага, 261.5 сая төгрөгийн зөрчил арилгуулах зөвлөмж хүргүүлээ./Хавсралт 4/

Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг ИНХ-аар хэлэлцүүлээгүй, хэлэлцүүлсэн боловч хуралд оролцогчдын ирцийг гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, тухайн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх, зорилтот бүлэг өгөөж хүртэх эсэх, иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх, төслийн нийт өртөг зэрэг үзүүлэлтүүдийг тооцоолоогүй зөрчил байна. Тухайлбал:

- Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Бууцагаан сумд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдэд нээлттэй хэлэлцүүлж иргэдээс санал авч эрэмбэлсэн гэх боловч түүнийг нотлох баримтгүй, багийн ИНХ-ын тогтоол, хурлын тэмдэглэлгүй;
- Говь-Алтай аймагт Бигэр, Дарив, Дэлгэр, Халиун, Цогт, сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлыг сумын ИНХ-аар хэлэлцүүлж баталсан баримтгүй, Бугат, Дэлгэр сумын иргэдээс авсан санал асуулгын хуудас нь батлагдсан маягтаар өгөгдөөгүй, санал өгсөн хүний овог нэр, гарын үсэг зурж баталгаажуулаагүй, эрэмбэлсэн баримт материал байхгүй, багийн ИНХ-ийн тогтоол нь батлагдсан тэмдэглэлийн маягтын дагуу хөтлөөгүй, оролцогчийн мэдээлэл тодорхойгүй, хуралд оролцогчдын гарын үсгээр баталгаажуулаагүй, мөн Бугат, Дарив, Жаргалан, Тонхил, Халиун, Хөхморьт, Цогт сумууд санал эрэмбэлэлт хийж дүгнэлт гаргах ажлын хэсгийг томилоогүй, сумын ИТХ-д хэрэгжүүлэх ажлын тоо төсвийн төслийг өргөн барьсан баримт материалгүй.

Дээр дурдсан зөрчлийг орон нутгийн удирдлага гаргасан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.1.1, 12.2.1.б, 12.2.1.в, 12.2.2 дахь заалтыг зөрчсөн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтан гарсан байна.

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д “Баг, хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна”, 63.2-т “Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны ИНХ дээр гарсан саналыг ИНХ хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно” гэж заасан байна.

Гэтэл дор дурдсан аймаг, нийслэлийн удирдлага иргэдийн саналаар дэмжигдээгүй, санал авч эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээг баталж,



хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4¹³, 60.3.6¹⁴, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.1¹⁵, 6.3.5¹⁶, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.2¹⁷ дахь заалтыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал:

- Говь-Алтай аймгийн Алтай, Бигэр, Бугат, Дэлгэр, Халиун, Цогт, Эрдэнэ, Есөнбулаг сум нь иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй 32 төсөл арга хэмжээнд 369.8 сая төгрөгийн төсвийг сумын ИТХ-аар баталсан;
- Дорноговь аймаг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төсөл, арга хэмжээний саналыг иргэдээс авч эрэмбэлсэн хэдий ч, иргэдээс дэмжигдээгүй 191.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн;
- Өмнөговь аймаг нийт 389.2 сая төгрөгийн ажлыг иргэдийн саналыг авч эрэмбэлээгүй төлөвлөгөөнд тусгасан;
- Хэнтий аймаг нийт 159.7 сая төгрөгийн 23 арга хэмжээ нь орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдээгүй ч эрэмбэлэгдсэн жагсаалтад орсон;
- Нийслэлийн СХД, БНД-ийн ИТХ нь иргэдийн санал аваагүй 70.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан нь нийт төсөл, арга хэмжээний 16.2%-ийг эзэлж байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд иргэдийн саналаар дэмжигдээгүй нийт 187 төсөл, арга хэмжээний 5,972.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4,368.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 1,604.0 сая төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн байна. /Хавсралт 4/

ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөвгүй, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2¹⁸, 29 дүгээр зүйлийн 29.4¹⁹, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7²⁰, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.3²¹ дахь заалтуудыг зөрчин зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн нь ОНХС-ийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Тухайлбал:

- Говь-Алтай аймаг ОНХС-аас 2,272.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 32 төсөл арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол хийгдээгүй байхад, Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Тонхил, Халиун, Хөхморьт, Цогт, Чандмань, Шарга, Эрдэнэ, Есөнбулаг сумууд нь 895.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 79 төсөл арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол хийгдээгүй байхад ИТХ-аар төсөв тавьж баталсан;

¹³ нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;

¹⁴ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ;

¹⁵ Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан зүйлийг баримтлах;

¹⁶ Иргэдийн оролцоог хангасан байх;

¹⁷ Тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн байх;

¹⁸ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох;

¹⁹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана;

²⁰ Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх;

²¹ хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх.



- Дорноговь аймаг 2017 онд зураг төсөвгүй, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдээгүй, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт боловсруулаагүй 407.2 сая төгрөгийн өртөг бүхий 17 ТАХ-г баталж, хэрэгжүүлсэн;
- Өмнөговь аймгийн Баян-Овоо, Манлай, Ноён сумд 482.7 сая төгрөгийн өртөг бүхий 7 арга хэмжээг Сангийн сайдын 43 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7 дахь заалтыг хэрэгжүүлээгүй ТЭЗҮ, зураг төсөвгүй ажлыг төлөвлөж, хэрэгжүүлсэн;
- Хэнтий аймаг нийт 1,421.8 сая төгрөгийн 67 төсөл, арга хэмжээ ТЭЗҮ, зураг төсөвгүйгээр аймаг, сумын ИТХ-аар батлагдсан;
- Нийслэлийн ИТХ-ын 2017 оны 12/20 дугаар тогтоолоор Нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх 148 төсөл арга хэмжээг батлахдаа 1,281.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 46 төсөл, арга хэмжээг зураг төсөвгүй баталсан нь "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7 дахь заалтыг зөрчжээ.

Аудитаар Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7 дахь заалтын шаардлагыг хангаагүй нийт 238 төсөл, арга хэмжээг 8,720.6 сая төгрөгөөр санхүүжүүлсэн зөрчил гаргасныг илрүүлж аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад 1.7 сая төгрөгийн акт, 5,184.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 166 албан шаардлага, 3,534.0 сая төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх 71 зөвлөмж тус тус хүргүүлээ. /Хавсралт 4/

Зарим үнэлгээний хороо, ажлын хэсэг холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна

ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд өмнөх оноос шилжүүлсэн 409, шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3,580, нийт 3,989 төсөл, арга хэмжээний хүрээнд бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд 5.0 хувь буюу 203 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 74.9 хувь буюу 2,989 ажлыг тендер шалгаруулалтын онцгой журмаар, 2.0 хувь буюу 81 ажлыг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар, 17.9 хувь буюу 716 ажлыг шууд худалдан авсан байна. /Хавсралт-2/

Хүснэгт 4. ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааны тоон мэдээлэл

(тоогоор)

Худалдан авах ажиллагааны журам							
Шинэ оны ажил	Нийт худалдан авах ажиллагаа	НТШ-ын журам	Тендер шалгаруулалтын онцгой журам			ОНО-той худалдан авах ажиллагааны журам	Шууд худалдан авалт
			ХТШ	Харьцуулалтын арга	Гэрээ шууд байгуулах		
3,580	3,989	203	40	768	2,181	81	716

Эх сурвалж: Аймаг, нийслэлийн ТАГ-ын аудитын тайлан.

Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон зарим үнэлгээний хороо, ажлын хэсгүүд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1²², 7.2²³, 8 дугаар зүйлийн

²² Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:...

²³ Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө.



8.5²⁴, 14 дүгээр зүйлийн 14.1.5²⁵, 26 дугаар зүйлийн 26.4²⁶, 29 дүгээр зүйлийн 29.1²⁷, 29.2²⁸ 30 дугаар зүйлийн 30.1.3²⁹, 33 дугаар зүйлийн 33.2.1³⁰, 33.3³¹, 47 дугаар зүйлийн 47.4³², 47.6³³, 47.8³⁴, 49 дүгээр зүйлийн 49.1³⁵, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4³⁶ дэх заалтыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал:

- Орхон аймаг 270.0 сая төгрөгийн нийт төсөвт өртөгтэй дээвэр засварын 12 ажилд харьцуулалтын арга ашиглахдаа 3 болон түүнээс олон байгууллагад үнийн санал ирүүлэх урилга илгээгээгүй, хуулийн 33.2-т “Харьцуулалтын аргыг дараах байдлаар хэрэглэнэ: 33.2.1.техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх” гэж заасан заалтыг хангаагүй;
- 178.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дээвэр засварын нийт 8 ажилд харьцуулалт амжилтгүй болж, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 33.4-д дагуу шууд гэрээ байгуулахдаа тусгай зөвшөөрлийн гэрээ, ажилчид, техникийн чадварыг нотлох баримт ирүүлээгүй, хуулийн 14-16 дахь шаардлагыг хангаагүй гүйцэтгэгчидтэй гэрээ байгуулсан зөрчилтэй байна;
- Сэлэнгэ аймаг 53.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн нэгдсэн эмнэлэг, Мандал сумын нэгдсэн эмнэлэгт томограф аппарат суурилуулах, тээвэрлэх” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалгүй шууд худалдан авах аргаар гүйцэтгүүлсэн, сумдын ажлын хэсэг нь 322.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа нэг ч үнийн санал ирээгүй болон тендерийн материалын бүрдэл дутуу, шаардлага хангаагүй гэх үндэслэлээр тендерийг хүчингүй болгосон боловч шаардлага хангаагүй гэж хасагдсан болон огт үнийн санал ирүүлээгүй аж ахуйн нэгжид шууд гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлж, төсөвт өртөгөөр нь гүйцэтгүүлсэн;
- Сүхбаатар аймгийн сумд ОНХС-аар санхүүжигдэх 333.2 сая төгрөгийн өртөг бүхий 15 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.5, 19.1, 33.2.1 дэх заалт, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг зөрчсөн;
- Нийслэл 210.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээг зохион байгуулсан үнэлгээний хорооны 3 гишүүн АЗ сертификатгүй ТБОНӨХБӨҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь заалтыг зөрчсөн, 838.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл арга хэмжээг зохион байгуулсан үнэлгээний хорооны 58 гишүүн Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын хавсралтыг буюу Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг

²⁴ Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно;

²⁵ тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;

²⁶ Энэ хуулийн 26.2-т заасан этгээд, захиалагч байгууллагын төлөөлөгч энэ зүйлийн 26.3-т заасан тэмдэглэлд гарын үсэг зурна;

²⁷ Захиалагч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрд шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ;

²⁸ гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах;

²⁹ шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн

³⁰ техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх;

³¹ Энэ хуулийн 33.2.1-д заасан үнийн санал ирүүлэх хугацааг урилга илгээсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтооно;

³² Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна;

³³ Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна;

³⁴ Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна;

³⁵ Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална;

³⁶ “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”.



зөвшөөрсөн мэдүүлэг бөглөөгүй, 644.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 17 төсөл, арга хэмжээний тендерийн бичиг баримтыг захиалагчаар батлуулаагүй нь "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам"-ын 3.2 дахь заалтыг зөрчсөн, 374.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 15 төсөл, арга хэмжээний ХАА-г харьцуулалтын аргаар зохион байгуулахдаа үнийн санал авах албан бичиг 1-2 гүйцэтгэгч нарт хүргүүлсэн нь ТБОНӨХБӨҮХАТ хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалтыг зөрчсөн, 572.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 17 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулах болон шалгараагүй тухай мэдэгдлийг тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлээгүй нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 29.1 дэх заалтыг зөрчсөн. Үүнээс шалтгаалан тендерт шалгараагүй оролцогчийн ТБОНӨХБАҮХАТ хуулийн 54.1-д заасан гомдол гаргах эрхийг хязгаарласан байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтыг зөрчсөн 2,843.1 сая төгрөгийн зөрчил гаргасныг илрүүлж, 620.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад 1,018.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 44 албан шаардлага, 1,204.7 сая төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн. /Хавсралт 4/

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл, арга хэмжээнд сангийн хөрөнгийг зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйл³⁷, "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 7³⁸-д аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлсон байна.

Нэр бүхий аймаг, сумын удирдлага ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж санхүүжүүлсэн, сангийн хөрөнгийг урсгал зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1³⁹, "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.3⁴⁰, 4.4⁴¹, 4.5⁴², 4.6⁴³ дахь заалтыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал:

- Дархан-Уул аймаг Ахмадын хороонд "Соён гэгээрүүлэх төсөл"-өөр 5.0 сая, Залуучуудын ЖСИ байгууллагад "Инээмсэглэх Дархан төсөл"-өөр 3.0 сая, аймгийн Эмэгтэйчүүд холбоонд "Жирэмсэн эмэгтэйчүүдийн сургалтын төв төсөл"-өөр 5.0 сая, "Хүүхэд, залуучуудын соёлын оролцоо" ТББ-д 7.5 сая, "Өег Дархан клуб" ТББ-д 4.0 сая, "Аймгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгт" 2.2 сая, "Гэрэл ган үзэг" ТББ-д 1.0 сая, "Сэтгэлийн ариун дэм" ТББ-д 2.0 төгрөг, МХБИБҮХолбоонд 5.0 сая, "Оюуны эрдэм хөтөч ТББ-д 5.0 сая, "Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг" ТББ-д 5.0 сая, Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд 3.0 сая, Цэргийн штабын дадлага сургалтын талбай байгуулахад 3.0 сая төгрөг, "Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх" гэсэн заалтуудыг зөрчин 7 дугаар багийн ИНХ байгуулах засварын ажилд 3.0 сая, 12 дугаар багийн камержуулалтад 9.9 сая, хаягжуулах ажилд 3.0 сая, 4 дүгээр багийн 34 дүгээр байранд мэдээллийн самбарт 3.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
- Дорнод аймаг "Хүний хөгжлийг хангах, хөгжлийн индексийг дээшлүүлэх, аймгийн эдийн засаг, нийгэм, хүний хөгжлийн төлөө мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах, сургалт, судалгаа, шагнал урамшуулал, эрүүл мэнд-спорт, хүүхэд-боловсрол, соёл урлагийн төсөл арга хэмжээг санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх" 480.5 сая төгрөг зарцуулсан;
- Орхон аймаг Барилгачдын талбайн тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах ажилд 4.5 сая төгрөг, Баян-Өндөр сумын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах суурь

³⁷ Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг;

³⁸ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргүүд;

³⁹ орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ;

⁴⁰ Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан ОНХС-аас зарцуулахыг хориглосон зүйлд зарцуулахгүй байх;

⁴¹ "Аймаг, нийслэл, сум дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх";

⁴² Орон нутгийн төсвийн бус байгууллагад ОНХС-аас хөрөнгө зарцуулахгүй байх;

⁴³ ОНХС-ийн хөрөнгийн буцалтгүй тусламж, дэмжлэгт зарцуулахгүй байх.



судалгааны ажлын хэвлэмэл материалын зардалд 10.0 сая төгрөг баталсан боловч уг хөрөнгийг зориулалт бус буюу сумын сурталчилгааны хуудас, бэлэг дурсгалын зүйл авахад санхүүжүүлсэн, Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 4.8 “ОНХС-аас зарцуулах эх үүсвэрийг өөр бусад эх үүсвэртэй давхардуулахгүй байх” заалтыг зөрчин аймгийн ОНХС-аас Эрдэнэт сангийн хөрөнгөтэй давхардуулан аймгийн баяр наадмын зардалд 100.0 сая төгрөгийг давхардуулан баталж, зарцуулсан;

- Сэлэнгэ аймаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр 7-12 төрлийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр зааснаас малжуулах, малын тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх гэсэн 3 чиг үүргээс бусад чиг үүргийн 100 төсөл, арга хэмжээнд 2,092.1 сая төгрөгийг зарцуулсан;

Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээнд зарцуулах төсвийн хувь хэмжээг зааглаагүй, хөтөлбөр, төсөл арга хэмжээний нэршлийг тодорхой тусгаагүйгээс сангийн хөрөнгийг хөтөлбөр, төсөл арга хэмжээ нэрээр зориулалт бусаар зарцуулан, урсгал зардлуудыг санхүүжүүлж тус сангийн үр нөлөөг бууруулах, үр ашиггүй зардал гарах нөхцөлийг бүрдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60.3.1⁴⁴, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.3⁴⁵, 4.4⁴⁶ дэх заалтыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал:

- Дорноговь аймгийн Чулуунхороот сумын нийтийн эзэмшлийн гудамжны гэрэлтүүлгийн зардалд 1.1 сая төгрөгийг зарцуулсан, Гурванзагал сум ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны урсгал зардалд зориулж 1.1 сая төгрөгийг зарцуулсан, Хатанбулаг суманд 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Иргэдэд үйлчлэх төвийн засварын ажил”-ийг ОНО-той хийж гүйцэтгэсэн, Иххэт суманд 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бүрдэнэ багийн төв тохижуулах ажил”-ыг хийж гүйцэтгэсэн байна. Энэ ажлын төсөвт магадалшгүй ажлын зардалд 0.2 сая төгрөг тусгасан ба уг зардлаар нэмэлтээр ажил хийгээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, Алтанширээ сумын ОНХС-ийн данснаас 1.4 сая төгрөгийг НББ-ийн анхан шатны баримтгүй сумын ЗДТГ-ийн нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн, 2017 онд Даланжаргалан суманд ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ажлын гэрээний алдангид 1.5 сая төгрөг, 2018 онд 9.1 сая төгрөгийг тооцож авсан боловч үүнийг сумын хүү торгуулийн орлогын дансанд шилжүүлсэн, Эрдэнэ суманд 14.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бүрдэнэ булагт хамгаалалтын хашаа барих” ажлын төсөвт захиалагчийн хяналтын зардалд 0.3 сая төгрөгийг тусгасан боловч санхүүжилтийг бүрэн олгосон, Хөвсгөл сумын 19.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах” ажлын санхүүжилтийг үлдэгдэл болох 3.6 сая төгрөгийг сумын ЗДТГ-ын нярвын дансанд шилжүүлсэн. Энэ нь гүйцэтгэгч байгууллагын тухайн сумаас худалдан авалтын өглөг гэж тайлбарлаж байгаа ч анхан шатны баримтгүй, нотлох боломжгүй;
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд Гал түймрийн улмаас орон гэрэгүй болсон малчдад буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлэхэд 5.0 сая, сум үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойн ном хэвлүүлэх 7.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан, Дарьганга сум ОНХС-д Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх буюу удирдлагыг хэрэгжүүлэх зардалд 15.6 сая төгрөгийг зарцуулсан, Халзан сумын Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэсгийн кобаны гаднах авто зогсоол 1.8 сая төгрөгийг зарцуулсан;
- Завхан аймгийн Улиастай, Дөрвөлжин, Тосонцэнгэл, Отгон, Тэлмэн сумдад 57.1 сая төгрөгийн өртөг бүхий 23 төсөл арга хэмжээг зориулалт бус зарцуулсан;
- Хэнтий аймаг 2017 онд нийт 316.5 сая төгрөгийн 39 арга хэмжээг худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр хэрэгжүүлсэн байна. Үүний дотор “Үндэсний их баяр наадам”-ын морь, бөх, сурын шагналаас бусад 155.3 сая төгрөгийн зардал багтаж байна. Мөн тусгай шилжүүлгийн байгууллага хүүхдийн цэцэрлэг, биеийн тамир спорт, эрүүл мэндийн үйлчилгээг дэмжиж 82.4 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ, Орон нутгийн төсвийн байгууллагыг дэмжиж 6.4 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, харин 45.2 сая төгрөгийн 12 арга хэмжээ нь нийтийн эрх ашигт чиглэгдээгүй арга хэмжээнүүд байна. Үүнд: архины хамаарал бүхий иргэдэд зориулсан сургалт, сумын хилийн самбар босгох, лекц, хөтөлбөрүүдийн нээлт зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулсан;
- Хөвсгөл аймаг ОНХС-ийн хөрөнгийн 40.8 сая төгрөгийг зориулалт бус зүйлд зарцуулсан;

⁴⁴ Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ;

⁴⁵ Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан ОНХС-аас зарцуулахыг хориглосон зүйлд зарцуулахгүй байх;

⁴⁶ Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх.



Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэг, 60.3.1 дэх заалтыг зөрчин ОНХС-аас урсгал зардал гаргасан зөрчил байна. Үүнд:

- Увс аймгийн Өлгий сум телевизийн нэвтрүүлэг хийлгэхэд 1,500.0 мянга, Түргэн сум онцгой байдлын сургалтын үйл ажиллагаанд 1,500.0 мянга, ариутгалын бодис худалдан авахад 150.0 мянга, сумын аварга шалгаруулах биеийн тамирын уралдаан тэмцээний зардалд 1,000.0 мянга, Хяргас сум сумын тохижилт, цэцэрлэгжүүлэлт нэрээр 4,300.0 мянган төгрөг гаргаснаас 1,440.0 мянган төгрөгийг цэцэрлэгчийн урамшуулалд тус тус олгосон;

Түүнчлэн зарим аймаг, сумд ОНХС-ийн хөрөнгөөр ойн арга хэмжээ тэмдэглэж, баяр наадмын зардлыг жишиг хэмжээнээс хэтрүүлэн санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1⁴⁷, МУГЗ-ын 2010 оны 271 дүгээр тогтоолын 1⁴⁸ дэх заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Дархан-Уул аймаг улсын баяр наадмын зардалд аймаг 30.0 сая төгрөг батлуулан, зарцуулсан;
- Дорнод аймаг улсын баяр наадмын зардалд аймаг 80.0 сая төгрөг батлуулан, 70.0 сая төгрөгөөр зарцуулсан;
- Хэнтий аймаг үндэсний баяр наадмын зардалд 78.6 сая төгрөг зарцуулсан;
- Орхон аймаг үндэсний баяр наадмын зардалд 100.0 сая төгрөгийг баталж, зарцуулсан;

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр зориулалт бусаар зарцуулсан 1,579.7 сая төгрөгийн зөрчил гаргасныг илрүүлж 61.5 сая төгрөгийн 17 төлбөрийн акт тогтоож, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад 1,209.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага, 309.2 сая төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж тус тус хүргүүлэв. /Хавсралт 4/

ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу бүртгэл тайланд тусгаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг санхүүгийн бүртгэл тайланд тусгахгүй орхигдуулдаг зөрчил өмнөх онуудтай харьцуулахад энэ онд багассан боловч зарим аймгийн холбогдох албан тушаалтан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁴⁹, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2⁵⁰, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.6⁵¹ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг давтан гаргасан байна. Тухайлбал:

- Баянхонгор аймаг 2017 онд ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжиж ирсэн болон тайлант онд нэмэгдсэн 4,053.9 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагуудын санхүүгийн тайланд тусгасан боловч 650.8 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй;
- Булган аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр 2017 онд хийж дууссан нийт 817.2 сая төгрөгийн 109 төсөл, арга хэмжээг бүртгэлд тусгахаас 446.7 мянган төгрөгийн 56 ажил буюу 48.6 хувийг бүртгэл тайланд тусгасан байна. Нийт 370.5 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй;
- Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга 851.5 сая төгрөгийн санхүүжилтээр баригдаж, ашиглалтад оруулсан боловч тайлан бүртгэлд тусгаагүй;
- Хэнтий аймаг ОНХС-ийн санхүүжилтээр 2017 онд шинээр бий болсон 421.0 сая төгрөгийн 40 хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэж, Хэрлэн сумын “Гудамжны хонхор тэгшлэх”, Баян-Овоо сумын “Цагдаагийн байрны халаалт”, Бор-Өндөр сумын “Зам засвар”, Дадал сумын

⁴⁷ үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;

⁴⁸ Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож....

⁴⁹ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ...

⁵⁰ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

⁵¹ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ



“Бурваз”, Мөрөн сумын “Ногооны талбайн шуудууны засвар”, Хэрлэн сумын “Гудамжны тэмдэг, тэмдэглэгээ” гэх мэт нийт 412.4 сая төгрөгийн 22 хөрөнгийг бүртгээгүй байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг бүртгэл тайланд тусгаагүй 4,604.9 сая төгрөгийн зөрчилтэй холбогдуулан 57.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 3,026.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 1,521.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүллээ. /Хавсралт 4/

1.3. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байгаа нь ажлын чанарт сөргөөр нөлөөлж байна.

ТБОНӨХБАУХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д захиалагч нь бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавина хэмээн эрх үүргийг хуульчилсан.

Гэтэл гүйцэтгэсэн ажлыг ашиглалтад оруулах комиссын акт гараагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, гэрээний хугацааг баримтлаагүй, ажлын даалгаврыг өөрчилсөн, захиалагчийн хяналт тавиагүй, захиалагчийн хяналт тавьсан тайлан, акт үйлдээгүй зөрчил нийтлэг байдлаар аудитын явцад илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3⁵², 16 дугаар зүйлийн 16.5.2⁵³, 41 дүгээр зүйлийн 41.2.3⁵⁴, Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоол “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.12⁵⁵, 4.13⁵⁶, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.25⁵⁷ дахь заалтуудыг баримталж, эрх үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйг харуулж байна. Тухайлбал:

- Говь-Алтай аймгийн хэмжээнд хэрэгжсэн буюу гэрээ байгуулан санхүүжилт олгосон 3,884.2 сая төгрөгийн 233 төсөл арга хэмжээнээс 207.7 сая төгрөгийн 38 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллаагүй;
- Сэлэнгэ аймагт сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн, худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулсан 25 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хийхээс 9 төсөл, арга хэмжээний хяналтыг орон нутгаас, 12 төсөл, арга хэмжээний хяналтыг “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ гүйцэтгэсэн бол 70.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 4 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хийлгээгүй, мөн сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга угсралт, их засварын ажлыг сумын комиссын актаар хүлээн авч байгаа боловч шууд худалдан авах аргаар хэрэгжсэн нийт 104.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт хийгээгүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.

⁵² Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны ИТХ, ЗГ, УИХ-ын өмнө бүрэн хариуцна;

⁵³ батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;

⁵⁴ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

⁵⁵ Комисс нь дараах эрх, үүрэгтэй;

⁵⁶ Захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгч, гүйцэтгэгч нь дараах эрх үүрэгтэй;

⁵⁷ Барилга, байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно.



ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд болон дотоод аудитын алба ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж хэвшээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба тус тус хэрэгжүүлэхээр “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1⁵⁸, 9.2⁵⁹-оор тодорхойлж зохицуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1⁶⁰ дэх заалт, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.2-т заасны дагуу Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Дорноговь, Дундговь, Орхон, Өмнөговь, Увс аймаг, Нийслэлийн зарим дүүргийн дотоод аудитын албанаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд хяналт шалгалт явуулсан, Дархан-Уул аймгийн зарим сумд, Төв, Хэнтий аймаг дээрх зааврын 9.1 дэх заалтын дагуу хяналт тавьсан бөгөөд бусад орон нутгийн дотоод аудитын алба, хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд дээрх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу хүргүүлээгүй, тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1, 10.2-т сум дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас болон бүтэн жилийн тайланг аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлэх, аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар уг тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг томилж ажиллуулахаар заасан байна.

Гэвч Баянхонгор, Дорноговь, Дундговь аймгаас бусад аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэс ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх санал, зөвлөмжийн биелэлтийн талаар сумдын Засаг дарга, ОНХС хариуцсан ажилтан нарт үүрэг өгч ажиллаагүй нь ОНХС-ийн зааврын 10.1⁶¹, 10.2⁶² дахь заалтыг зөрчсөн байна.

Мөн ихэнх аймаг, сумын удирдлагууд орон нутгийн түвшинд Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтын талаар мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, олон нийтэд ил тод мэдээлэх, сурталчлах ажлыг хариуцан

⁵⁸ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана;

⁵⁹ОНХС-аас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ;

⁶⁰Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна;

⁶¹ Сум дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна;

⁶² Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмжийг сум дүүрэг бүрээр гарган аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар жил бүрийн 2 дугаар сарын 25-ний дотор хэлэлцүүлнэ.



хэрэгжүүлэхдээ ЗДТГ-ын мэдээллийн самбар ажиллуулахаас хэтрэхгүй хэрэгжүүлж байна.

1.4. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ БОЛОН ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БҮЙ ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ, ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Холбогдох хууль эрх зүйн актуудын зүйл, заалтууд хоорондоо зөрчилдөж байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-д “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж тодорхойлсон байна.

Үүний дагуу мөн хуулийн 59, 60 дугаар зүйлд ОНХНС, ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэр, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгох орлогын шилжүүлэг болон хуваарилалт, мөн зарцуулалтад хориглосон зохицуулалтыг хуульчилсан байна.

Төсвийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор МУЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор “ОНХНС болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал”, Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалаар “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” зэрэг эрх зүйн актуудыг батлан мөрдөж байна.

Дээрх хууль, эрх зүйн актуудын хоорондын нийцлийг хууль тогтоомжийн бичвэр болон агуулгыг харьцуулах замаар судлан үзэж, дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. МУЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэх тооцох аргачлал” нь Төсвийн тухай хуулийн зарим зүйл, заалттай зөрчилдөж байна.

Хүснэгт 5. МУЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэх тооцох аргачлал”-ын заалт, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтын харьцуулалт

№	Төсвийн тухай хууль	Аргачлал	Тайлбар
1	59.1.1 импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь;	2.1.1 импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 25 хувь;	Хувь хэмжээ зөрүүтэй,
2	59.1.3 орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;	2.1.3 орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив;	“дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг” гэх эх үүсвэр “аргачлал”-д нэмэлт оруулаагүй,
3	59.1.4.энэ хуулийн 56.2-т заасан төвлөрүүлэх хөрөнгө;	2.1.4. орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг тухайн шатны төсөвт үлдээж,	Төсвийн тухай хуулиар хүчингүй болсон байхад “аргачлал”-д



	Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/	үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлэх дүн.	хэвээрээ үйлчилж байгаа,
4	59.1.5 газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.	Энэ заалтыг хэрэгжүүлэх зохицуулалт журамд байхгүй.	Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон байхад “аргачлал”-д нэмэлт оруулаагүй,
5	60.2.3.орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг хасаж үлдэх хэсэг; /Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/	2.2.3.Төсвийн тухай хуулийн 56.2-т заасан орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашиг;	Төсвийн тухай хуулиар хүчингүй болсон байхад “аргачлал”-д хэвээрээ үйлчилж байгаа,
6	60.2.5 тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.	2.2.5. тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж;	“дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг” гэх эх үүсвэр “аргачлал”-д нэмэлт оруулаагүй,
8	59.2 Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна; 59.2.1.энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх; 59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах; 59.2.3.улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 60.2.6, 60.2.7-д заасан орлогын шилжүүлгийг 60 дугаар зүйлийн 60.6, 60.7-д заасан хувь хэмжээгээр хуваарилах.	9.2. Аймаг нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилахад энэ аргачлалын 3 дугаар зүйлд заасан мэдээллийг ашиглан мөн аргачлалын 4-8 дугаар зүйлд заасан итгэлцүүрүүдийг орон нутгийн үзүүлэлтэд дүйцүүлэн тогтооно. 9.4. Энэ аргачлалын 3.2.1-д заасан орон нутгийн хөгжлийн индексийг сум, дүүргийн түвшинд үнэн зөв, бодитой байдлаар гаргах боломжтой болох хүртэлх хугацаанд уг индексэд харгалзах 25 хувийг аргачлалын 3.2.2-3.2.4-т заасан үзүүлэлтүүдэд тэнцүү хуваарилах байдлаар орлуулан хэрэглэж болно.	Аймаг нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн хувь хэмжээ болон агуулга зөрсөн.

“ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэх тооцох аргачлал батлах тухай” Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт болон 3, 4 дүгээр заалтыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэх тооцох аргачлал батлах тухай” 230 дугаар тогтоолыг батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна.



2. Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын зарим заалт Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Хүснэгт 6. Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын зарим заалт, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтын харьцуулалт

№	Төсвийн тухай хууль	Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”	Тайлбар
1	59.1.3 орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;	6.1.5 орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив;	дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг гэх эх үүсвэр журамд тусгагдаагүй,
2	59.1.4 энэ хуулийн 56.2-т заасан төвлөрүүлэх хөрөнгө; Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/	6.1.2 орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлэх дүн.	Төсвийн тухай хуулиар хүчингүй болсон байхад журамд хэвээрээ үйлчилж байгаа,
3	59.1.5 газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.	Энэ зохицуулалт энэ журамд байхгүй.	Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон байхад “аргачлал”-д нэмэлт оруулаагүй,
4	60.2.3 орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг хасаж үлдэх хэсэг; /Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/	6.2.2 Төсвийн тухай хуулийн 56.2-т заасан орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашиг;	Төсвийн тухай хуулиар хүчингүй болсон байхад журамд хэвээрээ үйлчилж байгаа,
5	60.2.5 тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг	6.2.5 Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж;	“дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг” гэх эх үүсвэр журамд нэмэлт оруулаагүй,

Сангийн сайд нь 2014 онд “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг боловсруулан баталж, мөрдүүлэхдээ Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хавсралт болох “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ын 2.3.9-д “Эрх бүхий этгээд нь шийдвэрийг баталснаас хойш ажлын арван өдрийн дотор хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.4, 58.2.4, 58.3.2, 58.4.2-т аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах хуулийн зохицуулалттай байхад



“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.6-д “ОНХС-ийн хөрөнгийг буцалтгүй тусламж, дэмжлэгт зарцуулахгүй байх” хэмээн заасан нь дээрх хуулийн заалттай зөрчилдөж байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.11-т “Энэ хуулийн 60.3.6 дахь заалтад 58.1.8, 58.1.12, 58.2.11, 58.2.12, 58.2.15, 58.3.4, 58.4.3, 58.4.4, 58.4.9, 58.4.10-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээний зардал хамаарахгүй” гэж хуульчилсан байхад “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 1.1-д “...нутгийн засаг захиргаа иргэд, олон нийтийн оролцоотой, хамтын шийдвэрээр ил тод, хариуцлагатай захиран зарцуулах...”, 4.2-т “тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн байх”, 4.4-т “аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх” гэсэн заалттай, Тодруулбал төсөл, арга хэмжээг төлөвлөхөд баримтлах зарчимтай уялдахгүй, зөрчилдөх нөхцөл үүссэн байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.4-т орон нутагт олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар сонгон шалгаруулалт хийхийг түлхүү дэмжинэ хэмээн заажээ.

Төсвийн тухай хуульд орсон дээрх нэмэлт, өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээг холбогдох эрх бүхий албан тушаалтан тухай бүр хэрэгжүүлж ажиллаагүй байна. Иймд тус аргачлал, журмыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг бусад хууль, тогтоомжтой нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

Мөн ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7^{1.3}⁶³-т заасны дагуу Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ыг баталсан бөгөөд тус журмын 2.1-д “Сум дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах хорин сая хүртэлх төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотой сонгон шалгаруулахдаа захиалагч нь хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний хороо байгуулна” гэсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.1⁶⁴ дэх заалттай зөрчилдөж байна.

Барилгын тухай хууль болон дээрх журмын 2.2-т төсөл, арга хэмжээ нь ТЭЗҮ хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байхаар заасан бөгөөд сум орон нутагт ихэнхдээ 10.0-40.0 сая төгрөгийн өртөгтэй бага хэмжээний барилгын засварын ажлууд хийгддэг нь дээрх хууль болон журмын заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байна.

Иймд Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг бусад хууль, тогтоомжтой нийцүүлэн өөрчлөх зайлшгүй шаардлагатай байна.

Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилго бүрэн хангагдахгүй байна.

⁶³ Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам, заавар, жишиг баримт бичгийг санхүү, төсвийн асуудалд эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж мөрдүүлнэ;

⁶⁴ Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна.



ОНХС нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилготой орон нутгийн төсөвт дэмжлэг үзүүлж буй хөрөнгө оруулалт юм.

Дээрх зорилгыг хангахын тулд 2013-2017 онд нийт 655.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хуваарилсан байна. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тоон үзүүлэлтийг харьцуулж хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 7. ОНХС-ийн хөрөнгөөр 2014-2017 онд хэрэгжүүлсэн
төсөл, арга хэмжээний тоон үзүүлэлт

Төсөл, арга хэмжээ /тоо/	2014 он	2015 он	2016 он	2017 он	Нийт /тоогоор/
Батлагдсан ТАХ	7,346	5,227	5,311	3,827	21,711
Бүрэн хэрэгжсэн ТАХ	6,358	4,086	4,249	3,418	18,111
Дутуу хэрэгжсэн ТАХ	988	500	277	189	1,154
Огт хэрэгжээгүй ТАХ	-	641	785	220	1,646

Эх сурвалж: ҮАГ-ын 2014-2017 оны "Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт" аудитын тайлангаас. Дээрх мэдээлэлд 2013 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо ороогүй болно.

Аудитын дүгнэлтээр 2014-2017 онд нийт 21,711 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 18,111 ТАХ бүрэн хэрэгжсэн, 1,154 ТАХ дутуу хэрэгжсэн, 1,646 ТАХ огт хэрэгжээгүй байна.

Хэдийгээр улсын хэмжээнд 655 тэрбум төгрөгөөр 18,111 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн гэсэн тоон мэдээлэл байгаа боловч орон нутгийн иргэдэд тулгамдаж байгаа эрүүл мэнд, боловсрол, соёлын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахуйц бодитой бүтээн байгуулалтыг бий болгоогүй, хэт олон жижиг арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Аудитын явцад ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, иргэдийн тус сангийн талаарх мэдлэг, оролцоог дүгнэх зорилгоор түүврийн аргаар 14,923 иргэнээс тандалт судалгаа хийснийг авч үзвэл:

Хүснэгт 8. Санал, асуулгын дүн

№	Санал, асуулга	Үзүүлэлт	Дүн	Эзлэх хувь
1	Судалгаанд оролцсон хүний тоо		14,923	
2	Боловсрол	Дээд	5,719	38.3
		Дунд	3,525	23.6
		Бүрэн дунд	5,679	38.0
3	Орон нутгийн хөгжлийн сангийн талаар хэр мэдээлэлтэй вэ?	Хангалттай	7,655	51.3
		Хангалтгүй	7,267	48.7
4	Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх мэдээллийг хаанаас авсан бэ?	Засаг дарга, хороодын хэсгийн ахлагч	6,504	43.6
		Орон нутгийн мэдээллийн самбар, радио, телевиз	3,544	23.7
		Иргэний танхимын ажилтан	2,269	15.4
		Нутгийн иргэдээс	2,606	14.0
5	Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх холбогдох хууль тогтоомж, журам зааврыг судалж үзсэн уу?	Тийм	6,299	42.2
		Үгүй	8,624	57.8
6	Таны баг, хорооны Засаг дарга 2017 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хамгийн түрүүнд хийх шаардлагатай ажлуудын саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулсан уу?	Тийм	7,169	48.0
		Үгүй	2,775	18.6
		Сайн мэдэхгүй байна	4,979	33.4
7	Та энэ үйл ажиллагаанд оролцож саналаа өгсөн үү?	Тийм	7,245	48.5
		Үгүй	7,677	51.4



8	Засаг дарга ийнхүү авсан саналыг эрэмбэлж, хамгийн их санал авсан ажлуудыг иргэдэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн үү?	Тийм	5,970	40.0
		Үгүй	4,330	29.0
		Сайн мэдэхгүй байна	4,623	31.0
9	Та нээлттэй хэлэлцүүлэгт оролцсон уу?	Тийм	6,226	41.7
		Үгүй	8,361	56.0
10	Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд бодитой хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьдаг уу?	Тийм	6,385	42.8
		Үгүй	8,538	57.2
11	Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад хэр сэтгэл хангалуун байдаг вэ?	Хангалттай сайн	5,332	35.7
		Хангалтгүй	3,488	23.4
		Мэдэхгүй байна.	3,443	23.0

Хүснэгтээс дүгнэж үзвэл “Та ОНХС-ийн талаар хэр мэдээлэлтэй вэ?” гэсэн асуултад 7,655 иргэн буюу 51.3 хувь нь “хангалттай”, 7,267 иргэн буюу 48.7 хувь нь “хангалтгүй” мэдээлэлтэй гэж, “Та орон нутгийн хөгжлийн сангийн талаарх холбогдох хууль тогтоомжийг судалж үзсэн үү?” гэсэн асуултад 42.2 хувь нь “Тийм”, 57.8 хувь нь “Үгүй” гэж хариулсан нь судалгаанд оролцогчдын 53.2 хувь нь мэдээлэлгүй, холбогдох хууль журмыг судалж байгаагүй гэж хариулсан байна.


“Таны баг, хорооны Засаг дарга 2017 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хамгийн түрүүнд хийх шаардлагатай ажлуудын саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулсан уу?” гэсэн асуултад 7,169 иргэн буюу 48.0 хувь нь “Тийм”, 7,754 иргэн буюу 52 хувь нь “Үгүй”, “Сайн мэдэхгүй байна” гэж хариулсан.

Мөн “Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд бодитой хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьдаг уу?” гэсэн асуултад 6,385 иргэн буюу 42.8 хувь нь “Тийм”, 8,538 иргэн буюу 57.2 хувь нь “Үгүй” гэсэн байхад, “Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад хэр сэтгэл хангалуун байдаг вэ?” гэсэн асуултад 35.7 хувь нь “Хангалттай сайн”, 23.4 хувь нь “Хангалтгүй”, 23.0 хувь нь “Мэдэхгүй байна” гэж хариулсан байна.

Санал асуулгын дүнг нэгтгэн дүгнэвэл төсвийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлж, иргэдийн оролцоо хяналтыг бий болгох боломж бүрэн хангагдаагүй гэж үзэж болохоор байна.

Мөн 2013-2017 онд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн хэмжээг тухайн жилийн нийт хөрөнгө оруулалттай нь харьцуулж үзвэл жил бүрийн зөрчил буурахгүй, давтагдан гарсаар байна.

ОНХС-ийн 2013-2017 оны хөрөнгийн эх үүсвэр, илэрсэн зөрчлийн харьцааг графикаар, он тус бүрээр үзүүлбэл:



Эх сурвалж: YAГ-ын 2014-2017 оны “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт” аудитын тайлангаас.



ОНХС-ийн 2013-2017 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9. ҮАГ-ын 2013-2017 он хийсэн ОНХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн зөрчил /тэрбум төгрөгөөр/

Илэрсэн зөрчлийн төрөл	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Тухайн оны нийт төсөвт өртөг	197.3	227.6	149.2	154.2	107.9
Төсөвт өртгөөс илүү санхүүжүүлсэн	0.8	1.2	0.7	0.3	0.1
ТЭЗҮ, зураг төсөвгүй, захиалагчийн хяналт тавиагүй болон бусад	0.6	12.3	7.3	15.6	12.1
Бүртгэл тайланд тусгаагүй	4.7	24.5	10.5	7.7	4.6
Дутуу, чанаргүй, хугацаа хэтэрсэн	12.8	15.6	3.8	3.3	5.6
ХАА-ны журам зөрчсөн	10.3	9.2	6.7	2.0	2.8
Иргэдийн саналаар дэмжигдээгүй	3.7	15.8	13.4	5.0	5.9
Зориулалт бусаар зарцуулсан	13.3	8.6	5.4	4.1	1.6
Нийт зөрчлийн дүн	46.2	87.2	47.9	38.0	32.8
Тухайн оны нийт төсөвт өртөгт зөрчлийн эзлэх хувь	23.4%	38.3%	32.1%	24.6%	29.6%

Эх сурвалж: ҮАГ-ын 2014-2017 оны "Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт" аудитын тайлангаас.

Нийцлийн аудитын газраас ОНХС-ийн хөрөнгийн 2013 оны зарцуулалтад хийсэн аудитаар 46.2 тэрбум, 2014 оны зарцуулалтад хийсэн аудитаар 87.2 тэрбум, 2015 оны зарцуулалтад хийсэн аудитаар 47.9 тэрбум, 2016 оны зарцуулалтад хийсэн аудитаар 38.0 тэрбум, 2017 оны зарцуулалтад 32.8 тэрбум төгрөгийн зөрчлийг илрүүлж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн удирдлагад танилцуулж, тайланг УИХ-д хүргүүлэн, олон нийтэд мэдээлж ажиллаж байна.

Гэсэн хэдий ч зөрчлийн хэмжээ буурахгүй, давтагдан гарсан, сангийн хөрөнгийг олон жижиг урсгал зардалд зарцуулах, бүртгэл тайланд тусгахгүй байгаа зэрэг нь сангийн удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлж ажиллах эрх, үүрэг хүлээсэн албан тушаалтнууд үйл ажиллагаандаа сангийн хууль тогтоомжийг мөрдөж ажиллахгүй байгаатай шууд холбоотой байна. Энэ нь сангийн зорилго, зорилт бүрэн биелэгдэхгүй байх шалтгаан болж байна.

ОНХС-ийн хөрөнгийн 2017 оны зарцуулалтад хийсэн аудитаар нийт 32,870.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 833.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 19,474.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 12,562.7 сая төгрөгийн зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэв. /Хавсралт 4/

Хүснэгт 10. Аудитаар илэрсэн нийт зөрчлийг ангилж үзүүлбэл:

№	Зөрчлийн утга	/сая төгрөг/	
		Дүн	Эзлэх хувь
1	Зориулалт бусаар зарцуулсан	1,579.7	4.8
2	Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжүүлсэн	5,972.7	18.2
3	Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн	2,843.1	8.6
4	Дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтрүүлсэн	5,588.0	17.0
5	Бүртгэл тайланд тусгаагүй	4,604.9	14.0
6	ТЭЗҮ, зураг төсвийг нь батлаагүй	8,720.6	26.5
7	Захиалагчийн хяналт тавиагүй	1,850.8	5.6
8	Төсөвт өртгөөс илүү санхүүжүүлсэн	119.0	0.4
9	Орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдаагүй	337.2	1.0



10	Хэрэгжээгүй, санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй	205.1	0.6
11	Бусад	1,049.1	3.2
	Нийт	32,870.2	100

Нийт 32,870.2 сая төгрөгийн зөрчлийн 4.8 хувь буюу 1,579.7 сая төгрөгийн ажлыг зориулалт бусаар зарцуулсан, 18.2 хувь буюу 5,972.7 сая төгрөгийн иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжүүлсэн, 8.6 хувь буюу 2,843.1 сая төгрөгийн ажлыг худалдан авах ажиллагааны журам зөрчсөн, 17.0 хувь буюу 5,588.0 сая төгрөгийн ажлыг дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтрүүлсэн, 14.0 хувь буюу 4,604.9 сая төгрөгийн ажлыг бүртгэл тайланд тусгаагүй, 26.5 хувь буюу 8,720.6 сая төгрөгийн ажлын ТЭЗҮ, зураг төсвийг нь батлаагүй, 5.6 хувь буюу 1,850.8 сая төгрөгийн ажилд захиалагчийн хяналт тавиагүй, 5.2 хувь нь 1,710.4 сая төгрөгийн бусад зөрчлүүд эзэлж байна.

БҮЛЭГ 2. СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.

2.1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлээгүй байна.

МУЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 2.1-т Сангийн хөрөнгийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийг журамласан байна. Үүнд:

- 2.1.1. улсын төсвөөс олгох сангийн эргэлтийн хөрөнгө;
- 2.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдийн хандив, тусламж;
- 2.1.3. сангаас олгосон зээлийн хүүгийн орлого;
- 2.1.4. хугацаандаа эргэн төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алдангиас тус тус бүрдүүлэхээр заасан.

СХС-д улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг суманд жижиг, дунд үйлдвэрлэл хөгжсөн байдал, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, зээлийн эргэн төлөлт, ашиглалт, хэрэгцээ, шаардлага, орон нутгийн идэвх, санаачилга зэргийг харгалзан төсвийн болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтоохоор заасан боловч 2014 оноос хойш улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлээгүй, сангаас олгосон зээлийн эргэн төлөлтөд тулгуурлан сан өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж байна. Гэтэл журмын 2.1 дэх заалтад Зээлийн эргэн төлөлтийн орлогыг эх үүсвэрийн төрөлд хамруулаагүй байна.

СХС-ийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хариуцах бөгөөд СХС-ийн хөрөнгө оруулалтын бодлогыг уялдааг хангаж ажиллах, СХС-аас олгосон зээлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн хөтөлж, холбогдох мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах үүрэгтэй.⁶⁵

⁶⁵ Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.1.1, 3.1.4;